



Мэдээллийн Чөлөөт байдлын тухай Монгол Улсын хуулийн төслийн талаархи санамж бичиг

“19 дүгээр зүйл” байгууллагаас гаргав.

2003 оны 8 дугаар сар

I. ТАНИЛЦУУЛГА

Энэ санамж бичиг нь “19 дүгээр зүйл” байгууллагаас Монголын Мэдээллийн чөлөөт байдлын тухай хуулийн төсөлд өгсөн дүн шинжилгээг агуулсан баримт бичиг мөн. Монголын хуульчид болон бусад хамтрагч нарын ажлын хэсгээс боловсруулан гаргасан тус хуулийн төслийг судлан санал өгөх хүсэлтийг “19 дүгээр зүйл” байгууллагад тавьсан юм. Эдгээр санал нь тус хуулийн төслийн Англи хэл дээр албан бус орчуулгыг тулгуурлан хийгдсэн болно.¹

Монголд мэдээллийн чөлөөт байдлыг хүндэтгэн хангах явдлыг тус хууль гүнзгийрүүлэх тул уг хуулийн төслийг “19 дүгээр зүйл” байгууллагын зүгээс талархан дэмжиж байна. Хуулийн төсөлд мэдээлэл авах эрх, хэвлэн нийтлэх үүрэг, хүсэлт гаргах, мэдээлэл хүртэх эрхийг өргөн утгаар нь тодорхой тусгасан мөн хараат бус Мэдээллийн Комиссарын талаархи зүйл заалтыг оруулсан зэрэг дэвшилтэт талууд байна. Үүний зэрэгцээ, хуулийн төсөлд мэдээлэл хүртэх эрхийг хязгаарлах нөхцлүүдийг тодорхой зааж өгч чадаагүй зэрэг тодруулах шаардлагатай зүйл заалт байгаа нь түүний сул талууд болж байна. Мөн хуулийг хэрэглэгчид хэрхэн ашиглах талаар зааварчилсан бичиг баримт бүртгэхийг шаардсан заалт мөн мэдээлэгчийг болон сайн үйлсийн төлөө мэдээллийг задруулахад хамгаалалт үзүүлэх тухай заалтуудыг орхигдуулсан байна.

Монголын хуулийн төсөлд хийсэн доорхи задлан шинжилгээ нь *Олон нийтийн мэдэх эрх: Мэдээллийн чөлөөт байдлын хуулийн зарчим, (“19 дүгээр зүйл” байгууллага)*² *Мэдээллийн чөлөөт байдлын хуулийн загвар (“19 дүгээр зүйл” байгууллага,)*³ хэмээх хоёр 19 дүгээр бүлгийн үндсэн баримт бичигт тулгуурлан хийгдсэн болно. Эдгээр баримт бичиг нь мэдээллийн чөлөөт байдалтай холбоотой олон улсын болон харьцуулалтаар шалгарсан шилдэг туршлагыг ашиглан боловсруулагдсан. Уг хоёр ном нь энэ чиглэл дэх

¹ Артикл 19-ын санал нь алдаатай, ойлгомжгүй болсон орчуулгын төлөө хариуцлага хүлээхгүй

² (Лондон, 1990 оны 6 дугаар сар)

³ (Лондон, 2001 оны 7 дугаар сар)

олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг туршлагыг илтгэх бөгөөд дэлхийн зарим улсын мэдээллийн чөлөөт байдлын тухай хуульд задлан шинжилгээ хийхэд ашиглагдаж байсан юм.

II. ОЛОН УЛСЫН БА ҮНДСЭН ХУУЛИЙН ХЭМ ХЭМЖЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГҮҮД

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний баталгаа

Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын /ХЭТТ/ 19 дүгээр зүйл⁴ нь олон улсын заншлын эрх зүйн хэм хэмжээнийхээ хувьд бүх улс орнуудад үйлчилдэг бөгөөд хүний үндсэн эрх болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг дараах байдлаар заажээ:

Хүн бүр өөрийн үзэл бодолтой байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, үүнд үзэл бодлоо ямар ч хориг цээргүй баримтлах, аливаа үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан боломжтой арга замаар эрж сурвалжлах, олж ашиглах, түгээн дэлгэрүүлэх эрх багтана.

Иргэний ба Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт (ИУТЭОУП)⁵ нь 1974 онд Монгол Улс нэгдэн орсноор заавал даган мөрдөх ёстой баримт бичиг бөгөөд түүний 19 дүгээр зүйлд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг ХЭТТ-тай тун адил томъёололтойгоор баталгаажуулсан байдаг.

ИУТЭОУП-д нэгдэн орсноор оролцогч улсууд Пактад тусгагдсан эрхүүдийг түүн дотроо үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг зөрчихгүй хэмээн хүлээн зөвшөөрсөн хэрэг. Хэдий тийм боловч ИУТЭОУП нь улс орнуудад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг бусад үндсэн эрхүүдийн хамт хэрэгжүүлэх үүднээс нааштай алхмуудыг хийх, эдгээр эрхүүдийг хүндэтгэж үзэх үүрэг хүлээлгэдэг. “Энэ тунхаглалд тодорхойлсон эрхүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоомж гаргах болон бусад арга хэмжээг авах” үүргийг Пактын 2 дугаар зүйлээр улс орнуудад хүлээлгэжээ. Өөрөөр хэлбэл Засгийн газар олон хэлбэрийн хүчирхэг, хараат бус хэвлэл мэдээлэл хөгжиж, ингэснээр олон нийтийн мэдэх эрхийг гүйцэлдүүлэхүйц орчинг бүрдүүлэх үүрэгтэй болж байна.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний баталгаанууд бүс нутгуудын хүний эрхийн гурван гол баримт бичигт, тухайлбал, Европын Хүний эрх ба тулгуур эрх чөлөөг хамгаалах Конвенцийн 10 дугаар зүйл (ЕХЭТЭЧХК)⁶, Африкийн Хүний ба ард түмний эрхийн Хартийн 9 дүгээр зүйл⁷, Америкийн Хүний эрхийн Конвенцийн 13 дугаар зүйлд⁸ тус тус тусгалаа олжээ. Хэдийгээр эдгээр системээс баталсан шийдвэр, мэдэгдэл нь Монгол улсад шууд хамаарахгүй ч эдгээр нь бүх дэлхийн чармайлт болсон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хүрээ, утга санааны баталгааг хангаж байгаа юм.

Нийтийн захиргааны байгууллагын албан тушаалтанд хадгалагдаж буй мэдээллийг хүртэх эрхийг өөртөө багтаадаг мэдээллийн чөлөөтэй байдал нь олон улсын гэрээгээр баталгаажуулсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний чухал хэсэг болдог. Мэдээллийн чөлөөт байдлын ач холбогдолд өчүүхэн ч эргэлзэх зүйлгүй. 1946 онд болсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хамгийн анхны чуулганаар баталсан 59(1)-дүгээр тогтоолд:

⁴ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны 217 (III) тогтоол

⁵ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А (XXI) тогтоол, 1976 оны 3 дугаар сарын 23-нд хүчин төгөлдөр болсон

⁶ ЕХЭТЭЧХК № 5 нь 1950 оны 11 дүгээр сарын 4-нд баталсан, 1950 оны 9 дүгээр сарын 3-нд хүчин төгөлдөр болсон.

⁷ 1981 оны 6 дугаар сарын 26-нд Кения, Найроби-д баталсан, 1986 оны 10 дугаар сарын 21 - нд хүчин төгөлдөр болсон.

⁸ Коста-Рика, Сан Жозед 1969 оны 11 дүгээр сарын 22-нд баталсан, 1978 оны 7 дугаар сарын 18 нд хүчин төгөлдөр болсон Коста-Рика, Сан Жозе

Мэдээллийн чөлөөт байдал бол хүний үндсэн эрх бөгөөд НҮБ-ын анхаарлын төвд байдаг бүх эрх чөлөөний тулгын чулуу мөн⁹ гэж заажээ.

Мэдээллийг чөлөөтэй олж авах эрх нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний бүрэлдэхүүн хэсэг мөн болохыг НҮБ-аас хүлээн зөвшөөрсөн. Үзэл бодол, түүнийг илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч НҮБ-ын Хүний Эрхийн Комисс-д илгээсэн жил тутам гаргадаг илтгэлдээ энэ эрхийн талаар дэлгэрэнгүй тайлбар өгсөн байдаг. 1997 онд “Тусгай илтгэгч олон орны Засгийн газар ард түмэндээ мэдээлэл өгөхгүй байх хандлага маш их байгаад хатуу хяналт тавих хэрэгтэйг дахин мэдэгдсэн байдаг¹⁰. НҮБ-ын Хүний Эрхийн Комисс тусгай илтгэгчийг мэдээлэл хайх, хүлээн авах эрхийн тухай тайлбараа улам баяжуулах, энэ талаарх өргөдөл гомдолд өгөх ажиглалт, зөвлөмжөө өргөжүүлхийг” уриалан энэ сэдвээр гаргасан түүний тайлбарыг дэмжсэн юм.¹¹ Тусгай илтгэгчийн 1998 оны жилийн тайланд мэдээллийн чөлөөт байдал нь төрийн мэдэлд буй мэдээллийг хүртэх эрхийг багтаадаг гээд

Мэдээлэл хайх, хүлээн авах түгээх эрх нь ялангуяа Засгийн газарт байгаа бүх хэлбэрээр хадгалсан болон нөхөн сэргээгдэх системийн мэдээлэл хүртэх эрхийг хангахуйц идэвхитэй үүргийг төрд ногдуулсан.¹² гэж тунхагласан байна.

Түүний энэхүү үзэл санаа нь Хүний Эрхийн Комиссоос дахин дэмжигдсэн байна.¹³

Мэдээллийн чөлөөт байдал нь Америк болон Европын системд нарийн тодорхойлогдсон байдаг. 2000 онд Хүний эрхийн Америк Хоорондын Комиссоос Үзэл Бодлоо Чөлөөтэй Илэрхийлэх Эрх Чөлөөний Америк Хоорондын тунхаглалыг батлан гаргажээ.¹⁴ Түүний оршилд мэдээллийн чөлөөт байдлыг туйлын ойлгомжтойгоор тунхагласан байдаг:

Төрийн мэдэлд буй мэдээллийг хүртэх эрхийг баталгаажуулах нь Засгийн газрын үйл ажиллагааг ил тод болгон түүний хариуцлагыг өндөржүүлдэг бөгөөд ардчилсан нийгмийн тогтолцоог бэхжүүлнэ гэдэгт гүнээ итгэж,

үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, хараат бус хэвлэл, мэдээлэл авах эрхийг хамгаалах үзэл санааг тусгасан Chapultepec Тунхаглалын зарчмуудыг дахин нотолж

гэсэн байдаг.

Энэ Зарчмууд нь төрийн мэдэлд буй мэдээллийг хүртэх эрхийг багтаасан мэдээллийн чөлөөтэй байдал нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний бүрэлдэхүүн хэсэг бөгөөд бие даан хүний суурь эрх болохыг гуйвалтгүйгээр хүлээн зөвшөөрсөн:

3. Хүн бүр мэдээллийн санд байгаа эсвэл энэ нь олон нийтийн болон хувийн бүртгэлд хадгалагдаж байсан ч өөрийн тухай болон өөрийн өмчийн тухай мэдээллийг хурдан шуурхай, төвөггүй хүртэх, хэрэв шаардлагатай бол түүнд нэмж мэдээлэл оруулах, засварлах эрхтэй.

⁹ 1946 оны 12 дугаар сарын 14-д баталсан

¹⁰ Тусгай илтгэгчийн тайлан, Санаа бодол, үзэл бодлын эрх чөлөөг хамгаалах, дэмжих, НҮБ-ын баримт бичиг E/CN.4/1997/31, 1997 оны 2 дугаар сарын 4

¹¹ Тогтоол 1997/27, 1997 оны 4 дүгээр сарын 11, хэсэг 12(d)

¹² Тусгай илтгэгчийн тайлан, Санаа бодол, үзэл бодлын эрх чөлөөг хамгаалах, дэмжих, НҮБ-ын баримт бичиг E/CN.4/1998/40, 1998 оны 1 дүгээр сарын 28, хэсэг 14

¹³ Тогтоол 1998/42, 1998 оны 4 дугаар сарын 17, хэсэг 2

¹⁴ 108 дахь ээлжит хуралдаан 2000 оны 10 дугаар сарын 19

4. Төрийн байгууллагын мэдэлд байгаа мэдээллийг хүртэх нь хүн бүрийн үндсэн эрх мөн. Төр энэ эрхийг бүрэн эдлүүлэх явдлыг баталгаажуулах үүрэгтэй. Ардчилсан нийгэм дэх үндэсний аюулгүй байдалд бодит гарцаагүй аюул нүүрлэх үед хуулиар урьдчилан тогтоосны дагуу энэ зарчмыг хязгаарлаж болно хэмээн зөвшөөрдөг.

гэсэн байдаг.

Европт Европын Холбоо, Европын Зөвлөл¹⁵ хоёул мэдээлэл авах эрхийн ач холбогдлыг дахин давтсан байдаг. 2002 оны 2 дугаар сард Европын Зөвлөлийн дэргэдэх Сайд нарын Хороо Албан хэргийн бичиг баримтыг хүртээмжтэй болгох тухай Зөвлөмж баталсан. Уг баримт бичигт Улс орнууд энэхүү чухал эрхийн ач холбогдлыг чухалчлан үзэхийн тулд мэдээллийн чөлөөт байдлын тухай хуулийг батлан гаргах нь зүйтэй гэсэн байдаг.

Гишүүн орнууд төрийн байгууллагын эзэмшиж буй албан хэргийн бичиг баримтыг шаардсан үедээ үзэх хүн бүрийн эрхийг баталгаажуулах ёстой. Энэ зарчмыг хэрэглэхдээ яс үндэсийг хамруулан ямар нэгэн үндэслэлээр ялгаварлан гадуурхах ёсгүй гэжээ.

Өнгөрөгч арваад жилийн хугацаанд Фижи, Энэтхэг, Израйль, Ямайка, Япон, Мексик, Пакистан, Перу, Өмнөд Африк, Өмнөд Солонгос, Тайланд, Тринидад, Тобаго, Их Британи болон Зүүн ба Төв Европын ихэнх улс оронд мэдээллийн чөлөөт байдлын тухай хууль батлан гаргажээ. Эдгээр улсууд хэдэн жилийн өмнөөс ийм хуультай болсон Швед, АНУ, Нидерланд, Австрали, Канад зэрэг орны эгнээнд нэгдсэн юм. Монгол улс мэдээллийн чөлөөт байдлын тухай сайн хууль батлан гаргаснаар мэдээллийн чөлөөт байдлыг баталгаажуулах чухал ач холбогдолтой алхам аль хэдийнээ хийж амжсан улсуудын жагсаалтад орох болно.

ҮНДСЭН ХУУЛИЙН БАТАЛГАА

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон мэдээллийн чөлөөт байдал нь Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд дараахь байдлаар хамгаалагдсан байна.

Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

16. Итгэл үнэмжилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал цуглаан хийх журмыг хуулиар тогтооно.

17. Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.

16,17 дугаар зүйл нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний олон улсын эрх зүйн баталгаанаас хэд хэдэн байдлаар нилээд хязгаарлагдсан байна. Хэдийгээр энэ нь мэдээллийг "хайх, хүлээн авах" эрхийг хамгаалсан боловч мэдээллийг "түгээх" эрхийг оруулаагүй байна. Мөн олон улсын эрх зүйд байдаг "хил хязгаарыг үл харгалзан" гэснийг энэ эрх баталгаажуулаагүй байна. Нилээд ноцтой зүйл гэвэл хэдийгээр 16,17 дугаар зүйлд уг эрхийн аливаа хязгаарлалт нь хуульд заагдсан бөгөөд хууль ёсны үндэслэлтэй байхыг шаардаж байгаа, боловч хязгаарлалт нь "ардчилсан нийгэмд шаардлагатай байх

¹⁵ Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны 2001 оны 5 дугаар сарын 30-ны тогтоол (ЕС) No 1049/2001 баримтыг

ёстой” гэснийг орхигдуулжээ. Практик дээр Засгийн газрын зүгээс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөнд саад тотгор учруулахаас хамгаалахад энэ нь хамгийн чухал хаалт болдог ба Үндсэн хуульд үүнийг орхигдуулсан нь ноцтой алдаа юм.

Нөгөө талаар, 16, 17 дугаар зүйлд нийтийн захиргааны байгууллагад байгаа мэдээллийг авах эрхтэй болохыг шууд бусаар заасан тул төрөөс нууцлах ёстой мэдээллээс бусдыг хүртэх эрхтэй гэж ойлгож болно.

Зөвлөмж:

- Үндсэн хуулийн 16,17 дугаар зүйлд дээрх шүүмжлэлийн дагуу олон улсын хэм хэмжээнд нийцүүлсэн нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгтэй.

III. МЭДЭЭЛЛИЙН ЧӨЛӨӨТ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭ

1. Үл хамруулах журам

Хуулийн төсөл дэх хамгийн ноцтой бэрхшээлүүдийн нэг нь мэдээлэл хүртэх эрхийн үл хамруулах журам юм. Хуулийн төсөл нь үл хамруулах нөхцлийг оруулж өгөхийн оронд нууцад хамаарах мэдээллийг бусад хуульд зааснаар гэж хялбарчилсан байна. Энэ мэтээр, 3.1. заалтад энэ хууль нь бусад хуулиар нууцад хамааруулсан мэдээлэлд хамаарахгүй гэж заажээ.

“19 дүгээр зүйл” байгууллага бүх мэдээлэл дараах 3 хэсэг сорилыг (болзлыг) хангаснаас бусад тохиолдолд нээлттэй болох ёстой гэж зөвлөж байна:

- Уг мэдээлэл энэхүү хуульд заасан хууль ёсны зорилгод хамааралтай байх
- Мэдээллийг задлах нь дээр дурдсан зорилгод заналхийлж, ихээхэн хор хохирол учруулахаар бол
- Дээрх зорилгод учруулах хор хохирол нь тухайн мэдээллийг задруулснаар гарах олон нийтийн ашиг сонирхлоос илүү бол

Энэ нь нэгдүгээрт, мэдээллийг өгөхгүй байх учир шалтгаан бүрийг тодорхой болгож өгнө гэсэн үг. Хоёрдугаарт, мэдээллийг өгөхгүй байх учир шалтгаантай холбож өгөх нь хангалттай бус харин мэдээлэлийг задруулснаар уг шалтгаант зорилгод бодитой хор хохирол учирахаар байх ёстой. Үүнээс гадуур мэдээллийг хаалттай байлгах шалтгаан байх учиргүй. Жишээлбэл, үндэсний аюулгүй байдал нь тодорхой мэдээллийг хаалттай байлгах хууль ёсны учир шалтгаан хэмээн хаа сайгүй хүлээн зөвшөөрөгдсөн хэдий ч үндэсний аюулгүй байдалтай холбоотой олон мэдээллийг нээлттэй болгоход үндэсний аюулгүй байдалд ямар нэгэн хор хохирол учирхааргүй байдаг. Эцэст нь хууль ёсны учир шалтгаанд хор хохирол учирахаар байсан ч олон нийтийн сонирхолын үүднээс мэдээллийг нээлттэй болгох нөхцөл байдлууд байх ёстой. Жишээлбэл, Зарим мэдээлэл хувийн нууцтай холбоотой боловч үүнийг задруулснаар газар авсан авилга, гэмт үйлдлийг илрүүлж болох тохиолдол байж болно.

Бусад орнуудад байдгийн адил Монголын нууцын тухай заалтуудыг бусад хууль тогтоомжид оруулан Мэдээллийн чөлөөт байдлын тухай хуулийг давуу эрхтэйгээр зохицуулалт хийх нь эдгээр зарчмуудыг орхигдуулахад хүргэдэг. Нууцын тухай хуулиуд нь ихэвчлэн ил тод засаглалын үзэл баримтлалыг агуулаагүй эсвэл олон жилийн өмнө ардчилал, ил тод байдлын тухай ойлголт өөр байсан үед хийгдсэн байдаг. Дээр дурьдсан хэм хэмжээтэй тэдгээр хуулийн бүгд биш ч ихэнх заалтууд нийцээгүй байдаг. Нууцын тухай олон хуулийг хэвээр байлгаад байх нь үнэн хэрэгтээ Мэдээллийн чөлөөт байдлын

тухай хуулийг үгүйсгэхэд хүргэнэ. Энэ нь үйлчилж байгаа нууцын журамд хэрэгжих бололцоо олгож харин ил тод засаглалын шинэ системийг бий болгох гэсэн Мэдээллийн чөлөөт байдлын тухай хуулийн чухал зорилгыг орхигдуулдаг юм.

Цаашилбал, мэдээллийг нээлттэй болгох шинэ, ерөнхий үүргийн дор одоогийн нууцын тухай хуулиуд нь хамгаалах ёстой нууцаа бүрэн гүйцэт хамгаалж чадахгүйд хүрч болох талтай. Өөрөөр хэлбэл: тус хуулиуд нь гуравдагч талын хувийн болон арилжааны мэдээллийн нууцыг хангалттай хамгаалж чадахгүй байх талтай.

“19 дүгээр зүйл” байгууллага Мэдээллийн чөлөөт байдлын тухай хуулинд нууцын талаархи заалтуудаа хялбарчилж үлдээхийн оронд мэдээллийг задлах үндсэн зарчимд үл хамаарах нөхцөлийг дэлгэрэнгүй зааж өгөх, хор хохирлыг цэгнэх мөн олон нийтийн ашиг сонирхлын дээгүүр тавих шаардлагуудыг нэмж хийж оруулахыг зөвлөж байна. Тэгснээр Мэдээллийн чөлөөт байдлын тухай хууль нь бусад хуультай зөрчилдөх үед тэдгээрийн нууцын тухай заалтуудаас давуу эрхтэй болно. Энэ нь нууц мэдээлэлтэй холбогдон гарах зүй ёсны ашиг сонирхлыг үр нөлөөтэйгээр олон улсын болон тулгуур хуулинд заасан ил тод байх хэм хэмжээтэй нийцүүлэн хамгаалж чадах үр дүнтэй болно.

Зөвлөмж :

- Үл хамааруулах журмыг дэлгэрэнгүй байдлаар хуулийн төсөлд нэмж оруулах
- Мэдээллийн чөлөөт байдлын тухай хууль нь нууцын заалтуудтай зөрчилдөх тохиолдолд давуу эрхтэй байх

2. Боломжийн бүх мэдээллийг нээлттэй болгох

Мэдээллийн чөлөөт байдлын тухай хууль нь боломжит бүх мэдээлэл нээлттэй байх зарчмыг барих ёстой. Энэ зарчмын дагуу ерөнхийдөө нийт олон нийтийн ашиг сонирхол буюу үл хамаарах журамд зааснаас бусад тохиолдолд бүх мэдээлэл нээлттэй байх ёстой. Хуулийн хүрээг өргөтгөх үүднээс мэдээлэл, нийтийн байгууллага аль алийг нь өргөн хүрээгээр тодорхойлох хэрэгтэй.

Хуулийн төсөлд Засгийн газрын болон, хувийн байгууллага, цаашлаад хуульд хувийн бизнес эрхэлдэг байгууллагууд уг хуулийн заасан процессыг дагаж мөрдөхөөр тодорхойлсон байна (4.1.3.,4.1.4.заалт). Тэгээд хуулийн төслийн 5.1. заалтад иргэн Засгийн газрын болон хувийн байгууллагуудаас мэдээлэл хүртэх эрхтэй гэж заасан байна. Гэсэн хэдий ч мэдээлэл хүртэхтэй холбоотой бусад олон заалтууд зөвхөн Засгийн газрын байгууллагуудад хамаарсан байна. Эдгээрт, мэдээлэл хүртэх гол зарчмуудыг тусгасан 6 дугаар зүйл, мэдээллээр хангах үүрэг ноогдуулсан 11 дүгээр зүйл, мэдээлэл авах хүсэлтийг бүртгэх 19 дүгээр зүйлүүдийг багтаасан гол заалтууд орсон байна. Хэрэв хуульд зөвхөн нийтийн байгууллагын ганц тодорхойлолт өгвөл илүү тохиромжтой, гэтэл эдгээрийг хувийн байгууллагуудыг багтаан нэг тодорхойлсон байснаа хуулийн төсөлд дахиад тусад нь бас тодорхойлсон байх юм. Ингэвэл байгууллагууд мэдээллээ нээлттэй болгох ганц үүргийг бүгдийг биелүүлэх ёстой болно.

Байгууллагын тодорхойлолтын хоёр дахь дутагдал нь мэдээллээ нээлттэй болгох үүрэг хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж буй хувийн байгууллагуудын хувьд хязгаарлагдсанд оршино. “19 дүгээр зүйл” байгууллагын зарчмын дагуу төрийн мэдлийн үйлдвэр, нийтийн корпораци, яамд, тэдний харьяа бус байгууллагууд, төрөөс байгуулсан хараат бус байгууллагууд (хагас төрийн бус байгууллага), шүүх эрх мэдлийн байгууллагууд, нийтийн ажил үүрэг гүйцэтгэдэг хувийн байгууллагууд (зам засах болон төмөр зам зохицуулах гэх

мэт) зэрэг өргөн хүрээний хувийн байгууллагын шинжийг агуулсан байгууллагуудыг тодорхойлолтдоо багтаахыг зөвлөж байна. Мэдээллийн чөлөөт байдлын тухай хуулийн зорилгын дагуу Засгийн газар эсвэл Төрийн эзэмшилд байдаг түүний хяналтад үйл ажиллагаа явуулдаг, эсвэл дийлэнх хувь нь Засгийн газрын сангаас санхүүждэг аливаа байгууллагыг нийтийн байгууллага гэж тодорхойлно.

Хуулийн төсөлд мэдээллийг "илэрхийлэгдэж буй хэлбэрээсээ үл хамааран хүмүүс, биет зүйл, үйл явдал, үзэгдлийн талаар агуулсан мэдээг" (4.1.6.заалт) гэж тодорхойлжээ. Энэ нь түүнд өргөн тодорхойлолт өгөх гэсэн оролдлого байж магадгүй боловч түүнийг мэдээ өөрөөр хэлбэл хүмүүс, биет зүйл, үйл явдал, үзэгдлийн талаар агуулсан мэдээ гэж тодорхойлон сүрхий хязгаарлажээ. Үүний оронд мэдээлэл бол хэлбэрээсээ үл хамааран дамжуулж болох бүх зүйл байж болно гэж тодорхойлбол илүү дээр байх болно. Бүр цаашилбал, тодорхойлолт нь хэлбэрээсээ үл хамааран гэж байгаа ч эх сурвалж /тухайн байгууллага буюу өөр байгууллагаас бэлтгэсэн эсэхээс үл хамааран/ болон хэзээ хийгдсэнээс болон тусгайлан ангилсан эсэхээс үл хамааран бүхий л мэдээлэлд нэгэн адил хамаарна гэж тодорхойлбол илүү зохимжтой байж болох юм.

Хуулийн төсөл нь иргэн гэж тусгайлан хандсанаа иргэнийг тодорхойлохдоо Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харъяалалгүй хүн гэсэн байна. (1.1., 4.1.2 заалт). Тус тодорхойлолт нь үнэн хэрэгтээ хүн бүрийг хамаарах ба бусад хуулийн холбогдох хязгаарлалтанд захирагдах юм (5.2.заалт). Хэдийгээр түүнийг нэлээд тойруу замаар хийсэн боловч энэ нь ойлгомжгүй байдалд хүргэж болох юм. Иймд маш энгийнээр энэ хууль нь хүн бүрт хамаарна гэж зааж болно.

Эцэст нь, хуулийн төсөлд төрийн бус байгууллага болон үйлдвэрчний эвлэл мэдээлэл хүртэх эрхтэй гэж онцлон заажээ. Энэ нь өөрөө хэдий зохимжтой заалт байлаа ч бусад бизнесийн болон улс төрийн намууд зэрэг байгууллагуудыг мэдээлэл хүртэх эрхгүй болгож байна. Эдгээр байгууллагууд мөн адил мэдээлэл хүртэх эрхтэй бөгөөд бусад орнуудад эдгээр байгууллагууд нь Мэдээллийн чөлөөт байдлын тухай хуулийн чухал хэрэглэгчид байдаг.

Зөвлөмж:

- Хуулийн төсөл нь хуульд заасан үйл ажиллагаагаа явуулдаг эсвэл нийтийн шинжтэй ажил үүрэг эрхэлдэг хувийн байгууллагыг багтаасан нийтийн байгууллагын ганц тодорхойлолттой байх ёстой.
- Мэдээллийн тодорхойлолтыг хэлбэр, хэзээ хийгдсэн, хэн бэлтгэсэн, тусгайлан ангилсан эсэхээс үл хамааран дамжуулж болох бүх зүйл гэж хялбарчлан заах хэрэгтэй.
- Иргэн гэсэн нэр томъёог түүний тодорхойлолтын хамт хуулиас авахыг бодолцох ба хууль нь хүн бүрт үйлчилнэ гэж хялбар байдлаар тусгах
- Бүх хуулийн этгээд мэдээлэл хүртэх эрхтэй байх ёстой

3.Мэдээлэл үнэн зөв байх нь

Хуулийн төсөлд хэд хэдэн газар нь “үнэн ба зөв” гэсэн санааг тусгасан байна. Жишээлбэл хуулийн төслийн 6.1.2. заалтад Мэдээллийн чөлөөт байдлын үндсэн зарчмын нэг бол Засгийн газар “мэдээлэл үнэн зөв” байх эсэхэд ажиглалт тавихыг мөн, 11.1.3. заалтад Засгийн газрын албан тушаалтан “иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах” үүргийг заасан байна.

Энэ үүргийн цаана юуг ойлгож байгаа нь бүхэлдээ ойлгомжгүй байна. Албан тушаалтан хүссэн мэдээллийг нь гаргаж өгөх ёстой нь маргаангүй зүйл. Гэхдээ хэрэв өгч буй мэдээллээ бодитой зөв болохыг албан тушаалтан батлан даах ёстой гэж үзэл байгаа бол энэ нь мэдээллийн чөлөөтэй байлгах систем хэрхэн ажиллах асуудлыг ойлгомжгүй болгоно. Нийтийн байгууллага өөрт хадгалагдаж байгаа аливаа мэдээллийг түүний үнэн зөвөөс үл шалтгаалан нээлттэй байлгах үүрэг хүлээсэн. Зарим мэдээлэл гуравдагч этгээдээс өгөгдсөн байх тохиолдол бий. Өөр нэг тохиролдолд Засгийн газрын мэдээлэл бэлтгэсэн ажилтнууд санаатай бус алдаа гаргаж болно. Үүний зэрэгцээ Засгийн газрын ажилтан санаатайгаар мэдээллийг гуйвуулах тохиолдол бий. Бүх тохиолдолд тэд бодитой хадгалагдаж байгаа мэдээллээ хялбар нээлттэй байлгах үүрэгтэй. Жишээ нь: Сэтгүүлч Засгийн газар олон нийтийг төөрөгдүүлсэн гэдгийг батлахын тулд мэдээлэл авахыг хүсч болох юм. Энэ тохиолдолд аливаа алдаатай мэдээллийг багтаасан мэдээлэл нь түүний авахыг хүссэн мэдээлэл байж болох юм.

Зөвлөмж:

- Мэдээлэл “үнэн ба зөв” байх гэсэн бүх заалтыг хуулийн төслөөс авах хэрэгтэй.

4. Хүсэлт гаргагчын үүрэг

10.2. Заалтад мэдээлэл авахыг хүссэн хүмүүст мэдээлэл авах журам, нөхцөлийг сахин биелүүлэх, мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэхдээ Үндсэн хууль, бусад хуулийг зөрчихгүй байх гэсэн хоёр үүрэг ногдуулсан байна.

“19 дүгээр зүйл” байгууллага нь эдгээр үүргийг хуульд оруулах шаардлагатай эсэхэд эргэлзэж байна. Хэрэв иргэн мэдээлэл авах журам, нөхцөлийг сахин биелүүлэхгүй бол мэдээлэл хүртэх эрх нь хасагдах магадлалтай байна. Тогтоосон журам, нөхцөлийг сахин биелүүлэх явдал нь сүрхий хориг болохоор болжээ. Хүн бүрийн хувьд Үндсэн хууль болон аливаа хууль тогтоомжийг зөрчихийг хориглодог болох нь хууль гэсэн тодорхойлолтоос илэрхий юм. Тиймээс мэдээллийн чөлөөт байдлын тухай хуульд иймэрхүү хориглолтыг нуршин оруулах шаардлага байхгүй.

Зөвлөмж:

- 10.2.-заалтад хүсэлт гаргагч нарт ногдуулсан үүргийг хуулийн төслөөс авах

5. Мэдээллийн Комиссарын бүрэн эрх

9.3. заалт нийтийн байгууллага бүрийн мэдээлэл хариуцсан ажилтан нар үйл ажиллагааныхаа тайланг Мэдээллийн Комиссарт гаргаж өгч байх үүргийг заасан байна. Цаашилбал 15.1.2. заалтад Мэдээллийн комиссар нийтийн байгууллагаас Мэдээллийн чөлөөт байдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажлын тайлан, мэдээг гаргуулан авах бүрэн эрхийг заасан байна. Энэ хоёр заалтын харилцан холбоос юу болох нь энд тодорхой бус байна.

Иймэрхүү төрлийн тайлангуудын ач холбогдол нь мэдээллийн талбар дахь олон нийтэд үйлчилдэг байгууллагын явуулж буй үйл ажиллагааг хянан шинжлэхэд оршдог. Арай илүү тодорхой болгох нь энэ үүргийн хүрээг мэдэгдэхүйц ойлгомжтой болгоно. Нэгдүгээрт, иймэрхүү тайланг нь жил бүр гаргаж өгч байх талаар тодорхой заах хэрэгтэй.

Хоёрдугаарт, тайланд зөвхөн мэдээлэл хариуцсан ажилтаны үйл ажиллагааны талаар бус харин нийтийн байгууллагын зүгээс мэдээллийн талбарт явуулж байгаа бүх үйл ажиллагааны талаар орох ёстой. Гуравдугаарт, дээр дурдагдсан хоёр заалтын хоорондын уялдааг тодруулах хэрэгтэй. Эцэст нь, хуулийн төсөлд иймэрхүү тайланд юу орох ёстой талаар илүү тодорхой чиглэлийг багтааж өгвөл тустай байх болно. Жишээлбэл: “19 дүгээр зүйл” байгууллагаас гаргасан загвар Хуулинд нийтийн байгууллагын гаргах жилийн тайлан дараах мэдээллийг агуулсан байх ёстой байдаг. Үүнд:

- а. мэдээлэл авах талаар ирүүлсэн нийт хүсэлт, тэдгээрт хэсэгчилсэн болон бүрэн байдлаар өгсөн хариулт, татгалзсан байдал, тэдгээрийн тоо
- б. мэдээлэл авах хүсэлтэд хэсэгчилэн буюу бүрнээр татгалзахдаа энэхүү хуулийн чухам аль зүйл заалтыг хэдэн удаа хэрэглэсэн
- в. шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзсанаас үүдэн давж заалдсан хэргийн тоо
- г. мэдээлэл авах хүсэлтээс олсон хураамжийн хэмжээ
- д. 17-р зүйлд /хэвлэн нийтлэх үүрэг/ заасан үйл ажиллагаа
- е. 19-р зүйлд /мэдээллийг хадгалах/ заасан үйл ажиллагаа
- ё. 20-р зүйлд /ажилтнуудыг сургах/ заасан үйл ажиллагаа

15.1.7 заалтад Комиссарын албан даалгавар, зөвлөмжийг биелүүлээгүй, хугацаа хожимдуулсан албан тушаалтны асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад нь тавьж хариу авах бүрэн эрхийг заасан байна. Энд хаана хандах гэж байгаа нь ойлгомжгүй байна. Харин энэ тохиолдолд шүүхэд ханддаг ёстой.

Зөвлөмж:

- 9.3. ба 15.1.2. заалтад заасан мэдээлэл хариуцсан ажилтаны үйл ажиллагааны талаар болон нийтийн байгууллагын үйл ажиллагааны тухай тайлангуудыг нэг тайланд хамааруулан ойлгохуйцаар өөрчлөх, иймэрхүү тайланг жил бүр гаргаж өгч байх, эдгээр нь нийтийн байгууллагын мэдээллийн талбарт явуулж байгаа үйл ажиллагааны талаар бүх мэдээллийг багтаасан байхаар тусгах.
- Нийтийн байгууллага нь Мэдээллийн Комиссарт гаргаж өгөх жилийн тайландаа мэдээлэлтэй холбоотой зүйлийг илүү тодорхой оруулах ёстой талаар анхаарах үзэх хэрэгтэй.

6. Хэвлэн нийтлэх үүрэг

Хуулийн төслийн 12.1-р заалтад нийтийн байгууллагуудад хүсэлт гаргаагүй байсан ч гол тодорхой хэлбэрийн мэдээллийг хэвлэн нийтэлж байх үүргийг оруулсан байна. Мэдээлийн төрөлд хуулийн төсөл, гол байгууллагуудын тушаал, шийдвэр, хүсэлт гаргах, шийдвэрлэх журам, байгууллагад хадгалагдаж буй мэдээллийн төрөл, хэлбэр мөн түүний дүрэм, бүтэц, төсөв, орон тоо, цалингийн сан зэрэг орсон байна.

Энэ нь ач холбогдолтой дэвшилттэй үүрэг юм. Гэсэн хэдий ч заавал хэвлэх ёстой мэдээллийн хэлбэрийг илүү тодорхой болгох хэрэгтэй. “19 дүгээр зүйл” байгууллагын гаргасан загвар Хуулинд, дараахь мэдээллийг идэвхтэй хэвлэн нийтлэх шаардлагыг нийтийн байгууллага бүрт тавьдаг. Үүнд:

- а. Тухайн байгууллагын зохион байгуулалт, эрхлэх ажил, үүрэг, санхүүгийн мэдээ
- б. олон нийтэд шууд хүргэдэг ажил үйлчилгээтэй холбоотой мэдээлэл
- в. тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан олон нийтийн зүгээс хүсэлт, гомдол гаргах механизм түүнчлэн тухайн байгууллагад гаргасан өргөдөл, гомдол, түүнд өгсөн хариултын товчоо
- г. тухайн байгууллагын мэдээлэл хадгалах тогтолцоо, хадгалагдаж

буй мэдээллийн төрөл, хэлбэр, хэвлэн нийтлэдэг мэдээллийн төрөл, мэдээлэл олж авах хүсэлт тавихдаа мөрдөх зарчим зэргийг багтаасан хэрэглэхэд хялбар гарын авлага

д. Ахлах болон удирдах албан тушаалтнуудын эрх мэдэл, үүргийн тодорхойлолт, шийдвэр гаргахдаа мөрддөг дэг

е. тухайн байгууллагын үйл ажиллагаагаа гүйцэтгэхтэй холбоотой дүрэм бодлого, журам, зааварчилгаа, гарын авлага

ё. олон нийтэд шууд хамаатай шийдвэр, бодлогын агуулга, уг бодлого шийдвэрийг гаргасан шалтгаан, зохих тайлбар, тулгуур материалын хамт

ж. тухайн байгууллагын бодлого тодорхойлох, эрхээ хэрэгжүүлэх ажиллагаанд олон нийтийн зүгээс нөлөөлөх буюу төлөөллөө бий болгох аливаа арга хэрэгсэл, процедур

Зөвлөмж:

- Хуулийн төсөлд нийтийн байгууллагаас мэдээллийг тогтмол хэвлэн нийтлэх үүргийг илүү тодоруулах талаар бодолцох

7. Нээлттэй хуралдаан

Хуулийн төслийн 13 дугаар зүйл төрийн байгууллагын хуралдааны нээлттэй явуулах байдлыг хангасан байна. Ийм хуралдаан хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд нийтэд нээлттэй байх, мөн хуулиар хамгаалсан нууцад хамаарахаас бусад бүх шийдвэрүүдийг нийтэд мэдээлж байх ёстой юм байна.

Энэ нь үнэлж үзмээр заалтууд ч харамсалтай нь маш цөөн Мэдээллийн чөлөөт байдлын тухай хуульд ийм зүйл орсон байдаг. Үүний зэрэгцээ энэ үүрэгтэй холбоотой илүү тодорхой зүйл шаардлагатай байна. Жишээ нь: Хуралдааныг нээлттэй явуулах нийтлэг үүрэг байхгүй байгаа үед иймэрхүү хуралдаан хаалттай байх цөөн үндэслэлүүд энд орсон байж болно. Энэ нөхцөлд эдгээр заалтууд нь нээлттэй хуралдааныг явуулахад хамгийн ач тустай байж болно. Нөгөө талаас хуулийн төслөөр хаалттай хуралдаанд өгөгдсөн мэдээллээр хангах, түүнийг явуулах үүргээс чөлөөлсөн үндэслэлүүд хэт ерөнхий юм. Ийм байдал нь нууцын талаар өнөө тогтсон зуршлыг өөрчилж чадахгүй. Иймд нээлттэй хуралдаанд мэдээллийн чөлөөт байдлын агуулгад нийцсэн илүү ухаалаг журам хэрэгтэй гэж хэлмээр байна.

Зөвлөмж:

- 3 дугаар зүйлд заасан нээлттэй хуралдааны ялангуяа хаалттай хуралдаан хийх үндэслэл эсвэл баталсан шийдвэрийг нийтэд мэдээлэхтэй холбоотой журмыг бүр сайн тодорхой болгох шаардлагатай. Энэ талаар тусгай хууль байх сонголтод анхаарч үзэх хэрэгтэй.

8. Гомдол

9. Гомдол

Хуулийн төслийн 15.1.9 заалтад Мэдээллийн Комиссар иргэдээс ирүүлсэн гомдлыг хянан үзэж шийдвэрлэх бүрэн эрхтэйг заасан байна. Энэ нь мэдээллийн Комиссарын хамгийн чухал эрх ба иргэдийн мэдээлэл үр нөлөөтэй түргэн шуурхай хүртэх явдлыг хангахад маш чухал байдаг. Гэсэн хэдий ч хуулийн төсөлд ийм эрх мэдэл нь яаж эдлэгдэхийг, ялангуяа ямар арга хэмжээ авагдаж болохыг тодорхой зааж чадаагүй байна. Жишээ нь, Мэдээллийн Комиссар эргэлзээтэй мэдээллийг шалгах, нийтийн байгууллагад мэдээллээ

нээлттэй болгох даалгавар өгөх, мэдээллээр хангах явдлыг учир шалтгаангүй хойшлуулсан, хэтэрхий өндөр хураамж авсан зэрэг асуудлуудад хандах бүрэн эрхийг ойлгомжтой болгох хэрэгтэй.

Мөн хариуцлагын механизмын тухай 25 дугаар зүйлд заасан дээд шатны байгууллага, Хүний эрхийн үндэсний Комисст мөн Шүүхэд гомдол гаргах заалттай Мэдээллийн Комиссар хэрхэн холбогдож байгаа нь ойлгомжгүй байна.

“19 дүгээр зүйл” байгууллага гомдол гаргах 3 үе шатыг зөвлөж байна. Эхнийх нь анхны хүсэлтийг татгалзсан тухайн төрийн байгууллагын дотоод хүрээнд, тэгээд Мэдээллийн Комиссар эсвэл Хүний Эрхийн Үндэсний Комисс гэх мэт бие даасан засаг захиргааны байгууллагад, тэгээд эцэст нь Шүүхэд гэсэн шатууд байдаг.

Зөвлөмж:

- Гомдол гаргах янз бүрийн шат, эрх мэдлүүдийг тодорхой болгох хэрэгтэй.

9. Бусад асуудлууд

Төлбөр

Хуулийн төсөлд үйлчилгээний хураамжийн хэмжээ нь уг мэдээллийг өгөхтэй холбогдон гарсан шууд зардлаас хэтэрч болохгүй гэж заажээ. Хуулийн төсөлд шууд зардалд юу хамаарахыг тодорхой болгож өгөх хэрэгтэй. Жишээ нь: Зарим хуульд мэдээллийг олшруулах зардлаар хязгаарлаж байхад бусад нь мэдээллийг хайх, бэлтгэх зардлыг оруулдаг. Нэмж хэлэхэд, хувийн чанартай мэдээлэл болон олон нийтийн ашиг сонирхолын тусын тулд хүсэж байгаа зарим мэдээлэлд төлбөр авахгүй эсвэл бага төлбөртэй байх тал дээр анхаарч үзэх хэрэгтэй юм.

Хүсэлтийг дамжуулах

11.3. заалтад нийтийн байгууллага өөрийн эрх хэмжээнд хамаарах хүсэлтийг “үндэслэлгүйгээр” өөр байгууллага, албан тушаалтанд шилжүүлж болохгүй гэж заасан байна. Иймд албан тушаалтанд хүсэлтийг дамжуулах эсэхийг бие дааж шийдэх эрхийг нь шууд олгосон хэт өргөн томъёолол байна. Хуулийн төсөлд ямар хүсэлтийг дамжуулж болох нөхцөлийн талаар тодорхой оруулж өгөх нь илүү дээр байх болов уу. Үүнд, анхны хүсэлтийг хүлээн авсан байгууллагад тухайн мэдээлэл байхгүй, эсвэл мэдээллийг задруулах нь үл хамаарах нөхцөлд хамрах эсэх нь эргэлзээтэй байгаа мөн бусад байгууллага энэ асуудлыг тодорхой болгох илүү чадвартай байж болох зэрэг багтаж болох юм.

Мэдээлэл авах хүсэлт

18.1. заалтад албан тушаалтанд хүсэлт тавихдаа өөрийн овог, нэр, байнга оршин суугаа газрын хаягаа бичсэн байхыг заасан байна. Энэ заалтад иргэд мөн ямар мэдээлэл хайж байгаагаа маш тодорхой заах талаар оруулж өгөх хэрэгтэй.

Хугацааны хязгаарлалт

23.1. заалтад заасан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногт багтаан хариу өгнө гэсэн байхад 19.4 заалтад хүсэлтийг өдөрт нь багтаан шийдвэрлэнэ гэсэн байх юм.

Эдгээр заалтууд өөр хоорондоо холбоотой эсэх эсвэл эдгээрийг оруулсны утга санаа юу байна вэ. 19.1.заалт нийтийн байгууллага хүсэлт хүлээн авах цагийн хуваарийг тогтооно нь гэсэн нь асуудлыг түвэгтэй болгосон байна.

Хүсэлтийг буцаах

22 дугаар зүйлд зохих ёсоор тавигдаагүй хүсэлтийг буцаах талаар заажээ. Үүнийг хүсэлт гаргах үед шийдвэрлэх асуудал болохоос биш араас нь бичгээр мэдэгдэх зүйл биш юм.

Зөвлөмж:

- Хуулийн төсөлд мэдээлэл авах хүсэлт гаргахтай холбоотой шууд зардалд юу хамаарахыг тодорхой болгох хэрэгтэй.
- Хувийн чанартай болон олон нийтийн ашиг сонирхолын тусын тулд хүсэж байгаа зарим мэдээлэл төлбөргүй байхаар эсвэл бага төлбөртэй байх тал дээр анхаарч үзэх хэрэгтэй.
- Хуулийн төсөлд ямар хүсэлтийг дамжуулж болох тухай нөхцөлийг тодорхой оруулж өгөх ёстой.
- Хүсэлт гаргахдаа ямар мэдээлэл хайж байгаагаа тодорхой бичихийг заах ёстой.
- Хүсэлтэд хариу өгөх хугацааны асуудлыг хуульд тодорхой болгох ёстой.
- 22 дугаар зүйлийг боломжтой бол тодорхой болгож зохих ёсоор тавигдаагүй хүсэлтийг тэмдэглэлд оруулаад шийдвэрлэх биш хурдан хугацаанд шийдвэрлэх арга хэмжээ авах ёстой.

10. Орхигдуулсан зүйлс

Хуулийг хэрэглэх заавар

Олон хуульд захиргааны байгууллагыг хуулийг хэрэглэж байгаа байдалд ажиглалт хийхийг шаарддаг ба хуульд хамааралтай бүх нийтийн байгууллага яаж мэдээлэл хүртэх талаар заавар гаргадаг. Энэ нь мэдээлэл хайхыг хүсч байгаа иргэнд хууль хэрэглэх чухал практик арга зам болж чадна.

Баримт бичгийг хадгалах

Нийтийн байгууллагын албан тушаалтан хүсэлт гаргагчийн хайж байгаа мэдээлэл нь хаана байгааг олж чадхааргүйгээр баримт бичгээ тааруу хадгалж байвал мэдээллийн чөлөөт байдлын хуулийн хэрэгжилтэд ноцтойгоор нөлөөлж болно. Энэ бэрхшээлийг шийдвэрлэх үүднээс мэдээллийн чөлөөт байдлын олон хуульд нийтийн байгууллагын албан тушаалтанд өөрийн баримт бичгийг зохистой нөхцөлд хадгалах үүргийг оруулж өгсөн байдаг. Жишээ нь: Их Британи Улсын 2000 оны Мэдээллийн чөлөөт байдлын тухай хуулийг баталсаны дараа Lord Chancellor (Хууль Зүйн Яамны Сайд) –аас иргэдэд үйлчлэх хамгийн сайн практик нэвтрүүлэх зорилгоор нийтийн байгууллагын албан тушаалтаны баримт бичгийг хадгалалт, удирдлага, устгалын талаар практикийн шинжтэй журам батлан мөрдүүлж байна.

Мэдээлэгчийг хамгаалах

Олон нийтийн ашиг сонирхлын тусын тулд гэм буруутай үйлдлийн тухай нууц мэдээллийг задруулсан хувь хүмүүс буюу мэдээлэгчийг ийм үйлдэл хийснийх нь төлөө ял шийтгэлээс хамгаалах ёстой. Энэ нь олон нийтэд хамаатай асуудал тэдэнд хүрч байх

бололцоог бий болгоход чухал ач холбогдолтой. Жишээ нь: Авилгал ба шударга бус явдал гарах, төрийн байгууллагыг ноцтойгоор завхруулан удирдах явдлыг илчлэхэд мэдээлэгчийн мэдээ чухал хувь нэмэр оруулна. Цаашилбал, мэдээлэгчид, хувь хүмүүс сайн санааны үүднээс нууцад холбогдох мэдээллийг задруулбал хариуцлага хүлээлгэхээс чөлөөлөх ёстой.

Зөвлөмж:

- Хуулийн төсөлд Мэдээллийн Комиссар болон нийтийн байгууллагууд хувь хүнд зориулсан хуулийг хэрхэн хэрэглэх заавар гаргах шаардлагыг оруулж өгөх ёстой.
- Хуулийн төсөлд нийтийн байгууллага өөрийн баримт бичгийг үр ашигтай нөхцөл байдалд хадгалахыг шаардах, энэ нь практикт хэрэгжих бүтцийг бий болгоход анхаарах ёстой.
- Мэдээлэгчид, хувь хүмүүс сайн санааны үүднээс нууцад хамаарах мэдээллийг нээлттэй болгосон тохиолдолд хариуцлага хүлээхээс чөлөөлөх ёстой.
- Хувь хүмүүс сайн санааны үүднээс болон хүндэтгэн үзэх шалтгаантайн улмаас мэдээллийг санамсарүй алдаа гарган задруулсан бол хариуцлага хүлээхээс чөлөөлөгдөх ёстой.

Орчуулсан Ж.Туул

Хуулийн хөтөлбөрийн зохицуулагч